

ТҮҮХ СОЁЛЫН СУДАЛГАА

ДӨЧИН ТҮМЭН МОНГОЛ УЛС
ХЭМЭЭХ НЭРИЙН ТУХАЙ

Эрдэмтэн М. Алтан-Оргилын “Дөчин түмэн Монгол Улс” хэмээх нэрийдлийн судлал гэдэг шинжилгээний өгүүлэлийг уншаад төрөгдсөн сэтгээдлээ товч бичье.

Юуны урьд профессор М. Алтан-Оргилын судалгаа шинэ сэргээг, лавдуун гүнзгий зүйл болохыг хэлэх хэрэгтэй.

Монголын түүхэнд Дөчин Түмэн Монгол мэтийн эргэлзээ төрөгдүүлэх, хянан нягтлууштай нэр томъёо, хэллэг олон боловч бид тэр бүхнийг төдий л үл хайхран ажиггүй явсаар дадсан юм. Иймэрхүү хайхралгүй хандлага нь түүхийн үнэн, түүхэн үйл явдлын үнэн зөвийг тодорхойлоход саад болох нь мэдээж.

Нөхөр Алтан-Оргил Дөчин Түмэн Монголын эргэлзээ бүхий мэдээ баримтыг сонгон авч сонин сайхан шинжилгээг нарийн нягт шинжлэн судалж зөв дүн гаргалга хийсэн байна.

Манай Монголд бусад ард түмний нэгэн адил зарим зүйлийг янз янзаар нэрлэсэн зүйл олон. Жишээлбэл: Аливаа юмны олныг доорхи мэтээр сонин нэрлэсэн байдаг. Далан хэлт шаазгай, Далан нөхөөст дээл, Есөн хэлний амьтан гэх мэт. Монголын сүүлийн Хаан Лигдэн биеэ Дөчин Түмэн Монголын Их Хаан хэмээн өргөмжлөн нэрлэснийг ард олон ерийн үгэнд Дөчин хаан гэж өгүүсэн баримт буй.

Эрдэмтэн М. Алтан-Оргилын судалгааны үр дүнд гарсан дүгнэлттэй би бүрэн санаа нийлж байгаагаа илэрхийлэн, цаашдын судалгаандаа лав их амжилт олохыг хүсэн ерөөе.

Ш. Нацагдорж
(Олон Улсын Монгол Судлалын Холбооны дэд ерөнхийлөгч,
Академич, Доктор)

1994 оны 12 сарын 4.

Хөх хот

“ДӨЧИН ТҮМЭН МОНГОЛ УЛС”
ХЭМЭЭХ НЭРИЙДЛИЙН СУДЛАЛ

Монголжин Алтан-Оргил

Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдэл нь эртний умар дахины угсаа үндэстэн Хүн (хүннү), Түргүүд, Монголын язгуур болон тэд нарын улс гүрний үүсэлд шууд холбогдсон хүнд, чухал бөгөөд будлиантай асуудал юм. Хоёр мянга гаруй жилийн турш монголч эрдэмтэд Хүн, Түргүүд, Монголын язгуур гарал болон хоорондох харьцааг үг хэл, ёс заншил өв уламжлал, шашин шүтлэг, газар орон, ахуй амьдралын хэлбэр, хуучны үлдэц, арьстны онцлог зэрэг олон талаас хянан судалсаар иржээ.⁽¹⁾ Эдгээр нь судалгаанд яриангүй дутагдаж болшгүй арга мөн боловч энэхүү хүнд чухал бөгөөд будлиантай асуудлыг судлахад Хүн-Түргүүд-Монголын өөрсдийн уламжлал яриа болон холбогдол бүхий үндсэн сурвалж бичгийн тэмдэглэлийг яасан ч олтгойлж болохгүй юм.

Энд олдой (мөхөс) би дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн үүсэл ирэлт болон түүний ухаагдхууныг сүвэгчлэхийн хамт түүнд шууд холбогдсон, Хүн, Түргүүд, Монголын язгуур гарлын асуудалд хувийн үзлээ дэвшүүлсүгэй.

Миний судалгааны арга зам бол Хүн-Түргүүд-Монголын уламжлал яриаг холбогдол бүхий Монгол, Түргүүд, Уйгуур, Манж, Төвд, Хятад, Согд, Санскрит, Перс..зэрэг эл зүйлийн үндсэн сурвалж бичгүүдийн тэмдэглэлтэй харьцуулсанд оршино.

Нэг.

1619 оноос одоо болтол Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн тухай адил бус үзэлтүүд

17 дугаар зууны эхний үеэс эхлэн Монгол, Манж, Хятад хаад, ноёд болон түүхийн эрдэмтдээс Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийг элдэвээр ойлгож тайлбарласаар иржээ.

Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдэл нь Монгол үндэстний доройтлыг дагалдаж тус зууны эхнээс ерийн хүмүүст мартагдах болов. Одоо үүнийг судалж тодлох нь эрдэм шинжилгээний талаар хүнд бөгөөд чухал ач холбогдолтой юмаа.

Олны мэдээжээр эртний Хүн хаант улсын үеэс эхэлж цэрэг, иргэдээ арван, зуун мянган, түмэн зэрэг аравтын зохион байгуулалтаар зохион байгуулдаг заншилтай байсан юм. Түүнийг Шилбэ (Сяньби) хаант улс, Түргүүд хаант улс, Кидан хаант улс, Монгол хаант улс ч урьд хожид залгамжлан хэрэглэж иржээ. Түмэнийг цэрэг, засаг захиргааны дээд шатны зохион байгуулалтын нэрээр хэрэглэхдээ заавал түмэн тоондоо яг тохирох биш, зарим үед илүү, дутуу ч байж болдог байлаа. 14-19 дүгээр зууны үеийн Монгол, Манж, Хятад, Перс сурвалж бичгүүдэд болон монгол ардын аман зохиолд түмэн нь улс, аймаг, хошуу ертөнц, тив, төр зэрэг нэрстэй харилцан хутгалдан хэрэглэгдэж иржээ. Ийнхүү Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлээс түүнийг дөчин түмэн хүн амтай Монгол улс, дөчин түмэн өрх амтай Монгол улс, дөчин аймаг юм уу дөчин хошуутай Монгол улс, дөчин түмнээр бүрэлдсэн Монгол улс, эсвэл тэр нь эрт дээр ямар нэгэн цаг үед дөчин түмэн байгаад умар дахины улс гүрний

тогтмол нэр болон хэрэглэгдэх болсон гэж олон янзаар ойлгож болно. Харин Дөчин Түмэн Монгол Улсын дөчин түмэн улсаар бүрэлдсэн Монгол Улс гэж хэлдэг хүн ер байсангүй. 1619 оны намар Монгол Хаант Улсын хамгийн сүүлчийн Лигдэн хаан Монгол, Манжийн харьцааг сайжруулахын төлөө Зүрчдийн хаан Нурхачид элч явуулж улсын бичиг өгчээ. Тэрхүү бичигт эхлэнгүүт: “Дөчин Түмэн Монгол Улсын эзэн баатар Чингис хаан, усны гурван түмэн Манжийн эзэн (хөндлөн) гэгээн хаан үг дуун үгүй мэнд суумуу хэмээн асуухаар илгээв”⁽²⁾ гэжээ. Лигдэн хааны энэхүү улсын бичиг нь тухайн үеийн Монгол, Манж хоёр этгээдийн харьцааг сайжруулж чадсангүй мөртлөө шинж яршиг төвгийг үүсгэжээ. Лигдэн хааны улсын бичигт Дөчин Түмэн Монгол Улс гэж түүнийг Монгол Улсын тогтмол нэр болгон хэрэглэж байгаа нь тодорхой. Гэтэл Хятад үсгийн Чин Улсын “Тайзу хааны магад хууль”-д энэхүү Монгол Улсын нэр болон Лигдэн хааны цолыг “дөчин түмэн олон Монгол Улсыг дайчилсан эзэн баатар Чингис хаан”⁽³⁾ гэж гажуудуулан орчуулжээ.

Энэхүү орчуулгаас Дөчин Түмэн Монгол Улсыг Монгол улсын тогтмол нэр гэж ойлгох аргагүй. Харин түүнийг цэрэг, засаг захиргааны талаар дөчин түмэнтэй, эсвэл бүгд дөчин түмэн хүн амтай буюу дөчин түмэн өрхтэй Монгол Улс гэж ойлгох болжээ. Энэхүү буруу ойлголт нь тухайн үеийн Монгол, Зөрчидийн зөрчлийг улам хурцатгаснаар үл барам одоо болтол зарим эрдэмтдийг эндүүрүүлж байна. Лигдэн хааны улсын бичгийг Нурхачи хүлээн аваад 1620 оны цагаан сард тусгай элч зарж түүнд эсэргүүцлийн бичиг илгээв. Тэрхүү бичигт: “Чину Дөчин Түмэн Монгол Улсын олныг надад юуну тулд оморхой. Би сонсвоос, танай Дайду хот юугаа Мин Улсын Хуан-у хаанд автахад дөчин түмэн монголоо цөм автаж ер зургаахан түмэн зугатаж харибай хэмээн сонслуга. Тэр зургаан түмэн монгол чамд бүрнээр үгүй болой. Ордос нэгэн түмэн, арван хоёр Түмэд нэгэн түмэн, тэртээ баруун этгээдийн гурван түмэн улс чамдор харъяагүй, өөрийн дураар яваа улс болой. Зүүн этгээдийн гурван түмэн улс цөм Чамдор буй юу? Гурван түмэн улс үгүй мөртлөө дөчин түмэн хэмээн эртний хуучны үгээр оморхон миний улсыг цөөн, ер гурван түмэн хэмээн доромжлохыг тэнгэр газар үл мэдэх буюу?”⁽⁴⁾ гэжээ.

Нурхачийн энэхүү бадаг үгэнд харилцан зөрчилтэй, мадагтай зүйлүүд олон байх бөгөөд зарим хэллэг нь яриангүй буруу юм. Дөчин түмэн монголоос зургаан түмэн зугатаж гарч ирсэн атлаа юунд цөм автагдсан гэж хэлэх юм бэ?

Нурхачийн үзсэнээр эртний үед, бодитой хэлбэл 1368 онд Монголын Юань улс их нийслэл Бээжин хотоо Мин улсад алдах үед дөчин түмэн Монгол байсан бөгөөд тэр нь тухайн үеийн Монголын хүн амын тоо буюу өрх амын тоог заасан бодит тоо биш, харин цэрэг, засаг захиргааны дээд шатны зохион байгуулалт болох түмэний ерөнхий тоо болно. Үүнийг Нурхачийн зургаан түмэний тухай ойлголтоос мэдэж болно. Гэвч 13, 14 дүгээр зууны үеийн эл зүйлийн сурвалж бичгүүдэд тухайн үеийн Монголыг цэрэг, засаг захиргааны талаар дөчин түмэн болгож хуваарилаж байсан гэдэг тэмдэглэл ер байсангүй. Дөчин түмэн болгож хуваарилаж байснаар бодсон ч дөчин түмэн бүгдээр дотор газарт байсан ёсон алга. 13 дугаар зууны үед

Чингис хаан болон түүний хүүхэд, ач нар Ази-Европ хоёр тивийг сундалсан монголын дөрвөн их хаант улсыг байгуулаад, монголын хүн ам дэлхий даяар бутарсан боловч олонхи нь мөн л төрөлх нутагтаа байсан юм. Үүнийг Юань улсын сүүлч Мин улсын эхний үеийн Монгол Хятадын хооронд дайн байлдаанд оролцож байсан Монгол цэргийн тоо болон хойшидын түүхт үйл явдлууд гэрчилж байна. Дахин Нурхачийн хэлдэг монголын зургаан түмэн нь Юань улс мөхсний хол хойно Даян хаан 1491 онд Монголын хаан сууринг залгамжилсны дараа хуваарилсан монголын Зүүн баруун гурваад түмнийг зааж байлаа. Зургаан түмэн Монголын дотор тэнгэр уулын дээд доод оронд нутаглаж байсан дөрвөн түмэн Ойрад багтагдахгүй юм. Хэрэв зургаан түмэн монгол дээр дөрвөн түмэн Ойрадыг нэмбэл тухайн үеийн бүх Монгол арван түмэн байсан бөгөөд зургаан түмэн биш юм. Даян хааны үеийн зургаан түмэн Монгол болон дөрвөн түмэн Ойрад бол зуу шахам жилийн урт удаан хугацааны дайн байлдааныг өнгөрүүлж их төлөв 13 дугаар зууны үеийн мянганы зохион байгуулалтын суурь дээр шинээр бүрэлдэн тогтсон аймгууд юм. Харин Нурхачийн хэлдэг шиг Юань улсын сүүлчийн үеийн дөчин түмэн Монголоос үлдэж хоцорсон зургаан түмэн биш юм. Үүнийг Нурхачийн залгамжлагч Манжийн Сэцэн хаан ч аль эрт мэдсэн байв.

1635 онд Лигдэн хааны хүү Эжэй хонгор Манжийн Сэцэн хаанд бууж өгөөд дараа жилийн цагаан сард тэр Манжийн Сэцэн хаанд хүндэтгэл цол өргөмжлөх хэмээн Монголын дөчин есөн ноёдыг тэргүүлж Солонгосын хаанд албан бичиг явуулжээ. Тэр үеэс эхлэн Чин улсын эл хаадын зарлигаар тогтоосон албан зохиолуудад: “Дөчин Түмэн Монгол Улсын эзэн” гэснийг Хятадаар “дөчин түмэн олон монголыг дайчилсан Монгол Улсын эзэн” гэж орчуулсныг залруулж “Дөчин Түмэн Монгол Улс Эзэн”⁽⁵⁾ гэж тусгай нэр болгон орчуулах болсон юм. Манжийн Сэцэн хаан хэдийгээр “түүний эцэг Нурхачийн Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн тухай буруу ойлголтыг залруулсан боловч энэ талын нөлөөг бүрмөсөн арилгаж чадсангүй билээ.

1619 оноос хойш зохиогдсон Монгол сурвалж бичгүүдийн дотроос “Гангийн урсгал” зэрэг цөөн хэдэн номыг гаргавал бусад нь ч адил бус хэмжээгээр Нурхачийн нөлөөнд өртжээ. Бодитой хэлбэл: Ордос Чуулган болон Улаанцавын Чуулганы урдын түүхчид Нурхачийн хэлснийг дагаж Юань улсын Тогоонтөмөр хаан дотор газраас зайлан гарч ирэх үед зургаан түмэн монгол зугатан гарч ирсэн гэдэг юм. Жишээлбэл: 1643-1662 оны үед Тоба тайжийн зохиосон “Их шар тууж”-д “Дөчин Түмэн монголын зургаан түмэн нь гарав, гучин дөрвөн түмэн ину хаагдаж хоцорвай”⁽⁶⁾ гэжээ. 1662 онд Сагаан Сэцэн “Эрдэнийн товч”-оо туурвихдаа энэхүү бадаг үгийн зарим алдааг залруулснаас гадна бусдыг нь тэр хэвээр нь хуулбарлан оруулжээ. 1840-1849 оны үед Жамбалдоржийн зохиосон “Болор толь”-д энэхүү бадаг үгийг шууд хуулбарлан авсангүй боловч мөн л Тоба тайж болон Сагаан Сэцэний хэлснийг дагаж Тогоон Төмөр хааныг “Зургаан түмэн Монгол Улсаа цуглуулж Барс хот хэмээх нэгэнийг барьж зүг Монгол тоотондоо хаан болж”⁽⁷⁾ гэдэг юм. Үүний хамт эдгээр номын Зохиолчдоос дөчин түмэнийг олонхидоо эрт урьдын цагийн Монголын

улс гүрний тогтмол нэр болгож хэрэглэдэг. Ийнхүү Тоба тайж, Сагаан Сэцэн, Жамбалдоржийн үзэлт нь хүмүүсийг өмнө хойно нь зөрчилтэй шиг санагдуулдаг юм. Жишээлбэл: Сагаан Сэцэний “Эрдэнийн товч”-д Тогоон Төмөр хааныг Бээжингээс зайлан гарч ирэх үед “дөчин түмэн монголоос зургаан түмэн, ину харьж гучин дөрвөн түмэн ину хаагдаж хоцорвой” гэж хэлээд, 1451 онд Ойрадын Эсэн тайши бүх монголын хаан болсныг хэлэхдээ “дөчин, дөрвөн хоёрын хаан болбай”⁽⁸⁾ гэдэг юм. Сагаан Сэцэний хэлдэг дөчин дөрвөн хоёр нь яриангүй дөчин түмэн. Монгол болон дөрвөн түмэн Ойрадыг хэлж байлаа.

16-19 дүгээр зууны үеийн монгол сурвалж бичгүүдэд дөчин, дөрвөн, хоёрын Монгол, Ойрад хоёр⁽⁹⁾ гэж хэлдэг байжээ.

Тэгвэл Тогоонтөмөр хааны үед зугатан гарч ирсэн зургаан түмэн монгол нь Эсэн хааны үед яагаад дөчин түмэн Монгол дөрвөн түмэн Ойрад болдог юм бэ?

Энэ үеийн дөрвөн түмэн Ойрад нь эрт урьдын цагийн дөчин түмэн Монголд багтах эсэхийг Сагаан Сэцэн бүр тодорхой хариулсангүй ажээ. Жамбалдоржийн “Болор толь”-д өмнө нь зургаан түмэн Монгол зугтан гарч ирсэн гэж бичээд хойно нь бас “Монгол урд дөчин түмэн байснаас хойно гучин түмэн ину Бээжинд үлдээд арван түмэн ину дөрвөн Ойрад болбой” гэжээ. Үүний хамт Жамбалдорж бас “Хөх Монгол дөрвөн бум илүү өрх”⁽¹⁰⁾ гэдэг. Тэр дөчин түмэн Монголыг хэтэрхий цөөн гэж дөрвөн бум илүү өрх гэж өөрчилжээ. Үүнээс үзэхэд Жамбалдорж ч Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн уг утга санааг ойлгоогүй байжээ. Жамбалдоржийн таамгалсан Хөх Монгол дөрвөн бум илүү өрх гэдэг нь ч тийм оновчтой биш юм. 13 дугаар зууны үеийн Монгол Хаант Улсын Монгол хүн амын тоо чухам хэдий байсныг одоо тодорхой мэдэх аргагүй юм. Гэвч Персийн алдарт түүхчин Рашид-Ад-Диний эмхэтгэн найруулсан “Түүхийн цуглаан” (“Судрын чуулган”) тэмдэглэлийг үндэслэвэл: 13 дугаар зууны үеийн тал нутгийн монгол, тус тусдаа эзэнтэй байсан Монгол, язгуур Монголын Тэрлигэн Дарлиган монголоос гадна ганц Ниргуун монголын хүн амын тоо зуун түмээс (нэг сая) хэтэрчээ.⁽¹¹⁾ 14 дүгээр зууны сүүлчээр Монголын дөрвөн их хаант улс мөхсний дараа монголын хүн амын тоог мөн л тодорхой бүртгэх аргагүй байлаа. Гэвч эл зүйлийн сурвалж бичгүүдийн тэмдэглэлийг үндэслэвэл Монголын төрөлхи нутаг дахь зөвхөн Хорчин Харчин хоёр аймгийн хүн амын тоо ядахдаа дөчин түмэнийг (400 мянга) хэтэрсэн юм.⁽¹²⁾

1635 онд Дөчин Түмэн Монгол Улс мөхөхөөс өмнө хойно Их Торгууд, Их Хошууд, цаашилбал Тэнгэр уулын дээд, доорд орноос Ижилдай, Хөх нуур, Төвдөд нүүдэллэсэн байдлаас хойш үлдсэн Дөрвөн Ойрадын хүн амын тоо 18 дугаар зууны дунд үед Чин Улсад их хэмжээгээр хядагдахаас өмнө жаран хоёр түм (620 мянга) байсан юм.⁽¹³⁾ Эдгээр нь Жамбалдоржийн таамаглал нь оновчтой биш гэснийг гэрчилснээр үл баран Монгол, Ойрадын хүн амын тоог тэдний нэрийдлийг үндэслэн дөчин түмэн Монгол, дөрвөн түмэн Ойрад гэж ойлгож болохгүй гэснийг харуулж байна.

1620 онд Нурхачи-аас Лигдэн хаанд эсэргүүцэл тавьснаас хойш 5 жилийн дараа өөрөөр хэлбэл Дөчин Түмэн Монгол Улс мөхөж сөнөх

түгшүүртэй байдалд орсон 1625 онд “Хаадын үндсэн хураангуй алтан товч” хэмээх түүхийн зохиол монголчуудын дунд дэлгэрсэн байжээ. Энэхүү түүхэн зохиолын зохиогчийн нэр нуугдаж орхигдосноос хүмүүс түүнийг зохиогчийн нэргүй “Алтан товч” гэж Лувсанданзангийн “Алтан товч”-оос ялган хэлдэг юм. Тус номд тэмдэглэсэнээр: Монголын Юань Улсын Тогоонтөмөр хаан Бээжингээс зугтан гарч ирэх үед дөчин түмэн монголоос гучин түмнээ орхиж арван түмнээ авч гарч ирээд Элбэг нигүлсхүй хааны үед арван түмэн монгол нь зургаан түмэн Монгол, дөрвөн түмэн Ойрад гэсэн хоёр хэсэг болж салсан гэжээ.⁽¹⁴⁾

Ингэж хэлсэн нь Нурхачитай зөвхөн тооны хувьд зөрүүтэй байгаа биш ээ, түүний цаана улс төрийн утга санаа нуугдаж байсан юм. Юу гэвэл, Мин улсын хятад хаад, Чин улсын Манж хаадаас Монгол Ойрадын хооронд зөрчил үүсгэж “Салган ноёрхох” харгис зорилгодоо хүрэхийн тулд элдэв зүйлийн заль мэх гаргаж зориуд Монгол, Ойрад хоёрыг хагацуулан хэлдэг байсан юм. Зохиогчийн нэргүй “Алтан товч”-д Монголын зургаан түмний дээр дөрвөн Ойрадыг нэмж арван түмэн Монгол болгож, арван түмэн Монголоо бүр угийн дөчин түмэн Монголдоо багтаан тоочисон нь яриангүй Монгол, Ойрад хоёрыг нягтруулж харийн ноёрхогчдын хагацуулах төрийн бодлогыг эсэргүүцсэн явдал байлаа. Энэхүү үзэл дурдалт нь 1625 оноос хойш зохиогдсон Чин улсын үеийн Гадаад дотоод Монголын түүхийн зохиолуудыг нийдэм нөлөөлжээ. Жишээлбэл: 1651-1675 оны үед Лувсанданзангийн зохиосон “Алтан Товч”, 1677 онд ар долоон Халхад зохиогдсон “Асрагч нэртийн түүх”, 1739 онд Дхарма Гүүшийн (Дармагүүш) зохиосон “Алтан Хүрдэн, мянган хэгээст”, 1775 онд зохиогдсон Ишбалданы “Эрдэнийн Эрхи” зэрэг Монгол түүхийн зохиолуудад ч Тогоонтөмөр хааны үед дотор газраас арван түмэн монгол зугатаж гарч ирсэн гэдэг юм.⁽¹⁵⁾ Ингэхдээ эдгээр номуудын зарим зохиогчийн үзэл, дурдалт нь хүмүүст шинэ ухаагдхууныг олгодог. Жишээлбэл: “Эрдэнийн Эрхи”-д Монголын Юань улсын үе болон түүнээс хойших монголын байдлыг хэлэхдээ: “Урдын цагт ширээний зүйл дөч байсны гуч нь Бээжинд хоцроод арав нь хойш буцаж ирсний дөрөв нь Өөлд хэмээдэг”⁽¹⁶⁾ гэжээ.

Олны мэдээжээр Ойрад Монголын баатарлаг тууль “Жангар”-т дөчин түмэн монголыг дөчин түмэн ертөнц гэж хэлдэг.

Жангарын Хааны өргөөг дөчин дөрвөн тэрэм дөрвөн мянган уньтай гэдэг. Жангарын хаан ширээг дөчин дөрвөн хөлтэй, дүүвэр шавар ширээ гэдэг. Дөчин нь Дөчин Түмэн Монгол дөрвөн нь Дөрвөн Түмэн Ойрад, дөрвөн мянганыг 13 дугаар зууны үеийн Ойрадын бэлгэ тэмдэг болж байлаа гэж олдой би “Жангар”-ын судлалын өгүүлэлүүддээ дахин давтан тайлбарлаж байсан юм. ⁽¹⁷⁾

Тэгвэл “Эрдэнийн Эрхи”-д тэмдэглэдэг “Ширээний хөл дөч” гэдэг нь алдаа байлаа. Үүнээс үзвэл, өнгөрсний монгол аман зохиол болон зарим түүхийн зохиолд Дөчин Түмэн Монголыг тулгуур төрөөр ойлгож Монголын хаан сууринг дөчин хөлтэй ширээтэй адилтган үздэг байжээ. Энд Монгол Хаант Улсын үеийн дөчин түмэн нь бодитой цэрэг, засаг захиргааны зохион байгуулалтын тоо, хүн амын тоо. өрх амын тоо биш гэснийг нэн тодорхой харуулж байна.

Дахин Лувсанданзангийн “Алтан товч”-д 1227 онд Чингис Хаан халисны дараа Монголын голомтыг сахисан Толуй болон түүний хүүхэд, ач нарыг “Их голомт дор төвлөн Дөчин Түмэн Монголын Эзэн бололуга” Монголын Юань Улсын Их Нийслэл одоогийн Бээжин хотыг “Дөчин Түмэн Монгол Улсын нэр төрийг аван суусан дөрвөн хаалгат дөрвөлжин их Дайду хот”, 1491 оны дараа шинээр хуваариласан Монголын зүүн, баруун гурваад түмнийг “Богд Чингис хааны зургаан түмэн” гэж буй.⁽¹⁸⁾ Эдгээрээс үзвэл Дөчин Түмэн Монгол Улс, Дөчин Түмэн гол, Дөчин Монгол зэрэг нэрийдэл Юань улсаас өмнө Монголь... Улс гүрний тогтмол нэр. болж хэрэглэгдээд иржээ. Дөчин Түмэн Монгол болон зургаан Түмэн Монгол нь түүхийн адил бус үе шатын Монголын Улс гүрний нэрийдэл байлаа. Даян хааны үеийн зургаан түмнийг Юань улсын үеийн Дөчин Түмэн Монголоос үлдэж хоцорсон гэж хэлж болохгүй юм.

18 дугаар зууны үед Гомбожав гэдэг Монголын хэл, түүхийн алдарт эрдэмтэн байсан юм. Тэр эрдэм чадвар, үзэл санаа эл талаараа 17-19 дүгээр зууны үеийн Монголын эрдэмтдийн дунд хамгаас оройлсон байжээ.

Гомбожав бол Чингисийн алтан урагтан болох бөгөөд Шилийн Голын Чуулганы Үзэмчин баруун хошууны гүн байжээ. 1690 онд Ойрад Монголын Зүүн Гар Хаант Улсын Галдан Бошогт Хаан Үзэмчний газраа ирж Манжийн эзэрхэгчдийг эсэргүүцэх явцад Гомбожавын гэр бүлийнхэн дэмжин туслаж байсан юм. Гомбожав өөрийн бие нь Бээжингийн Төвд сургаалын сургагчаар ажиллаж “Данжуур” номыг монголчлох ажилд оролцож “Мэргэд гарахын орон” болон “Дохионы бичиг” зэрэг Төвд монгол толь бичгийг найруулан зохиож, Монгол, Төвд, Манж, Хятад хэлэнд нэвтэрч “дөрвөн хэлийг эгүүлэгч их Гүүш” хэмээх алдар цолтой байжээ. Гомбожав нь хэл судлал, орчуулга, найруулгын талаар үлэмж нэрд гарсанаар үл барам түүх судлалын зарим талаар тухайн үедээ түрүүлж байжээ. Түүний төвдөөр зохиосон түүхэн зохиолч “Жанаг Чойнжун”-д Хятад оронд Хан улсын Мин ди (м.э 58-75) хааны үед Бурхан шашин эхлэн дэлгэрсэн, цагаан морин сүм бол Хятад оронд хамгийн эрт байгуулагдсан бурхан шашны сүм байжээ гэж зөв оновчтой дурдан гаргасан юм.

Олны мэдээжээр 16 дугаар зууны дундач үед шарын шашин монгол оронд дэлгэрснээс хойш шарын шашны хутагт, хувилгаад монголын хаад ноёдын дэмжилгийг олохын төлөө гуравдугаар Далай лама Содномжамцад бараа болж ирсэн Ширээт, Гэвшээс эхэлж Чингисийн алтан урагтаныг Энэтхэг, Төвдийн хаадаас гаралтай гэж ухуулах болсон билээ. Энэхүү үзэл нь 16-19 дүгээр зууны үеийн Монгол Төвдийн түүхийн зохиолуудад нийтлэг нөлөөлсөн юм.

Ийм байдлын доор зохиогчийн нэргүй “Алтан товч” зохиогдсоны 100 жилийн ой буюу 1725 онд Гомбожав нь “Гангын урсгал” гэдэг Монгол түүхийн зохиолоо туурвиж Чингисийн дээдсийг шууд Бутанцараас эхлэн бичиж шашны эл зүйлийн худал хуурмаг ухуулгын ялан давж түүхийн үнэн байдлыг баримталжээ. Дөчин Түмэн Монгол

Улс хэмээх нэрийдлийн талаар Гомбожавын үзэлт нь өвөрмөц онцлогтой юм.

“Гангын Урсгал”-даа Чингис Хаан монголын олон аймгийг нэгтгэж улс байгуулсныг бичихдээ онцгойлон: “Дөчин есөн улс эрхдээ хураагаад Их Монгол Улс хэмээн нэрийдвэй. Дөчин илүү улс эрхдээ хураагаад Их Монгол Улс хэмээн нэрийдвэй” гэж нэг нэрийг хоёр янзаар давтан өгүүлж уншигчдыг анхааруулсан билээ.

Ингэхдээ: Түрэг гаралтай Уйгуур зэрэг угсаа үндэстнийг ч Их Монгол Улсад багтаан тооцжээ.⁽¹⁹⁾ Гэтэл Юань Улсын Тогоонтөмөр хааныг дагаж дотор газраас зургаан түмэн монгол буюу арван түмэн Монгол зугтааж гарч ирсэн гэж ер дурдсангүй юм. Энэ нь Нурхачийн ганаарсаныг бүрмөсөн ялан давсныг гэрчилж байна. Энд Гомбожавын хэлдэг “дөчин есөн улс буюу дөчин илүү улс” -ыг тайлбарлах хэрэгтэй байна.

Түрэг-Монгол эртнээс аваад есийн тоог аливаа сайн сайхан, бүрэн бүтний бэлгэдлийн тоогоор үзэж хамгийн эрхэм дээд бэлгийг есөн цагаан бэлэг гэдэг байжээ. Ерийн хүмүүс бүр Лигдэн хааны хүү Эжэй Хонгорыг Монголын дөчин есөн ноёдыг тэргүүлж Манжийн Сэцэн хаанд бууж өгсөн, Манжийн Сэцэн Хаан тэд нарыг дөчин есөн хошуу болгон хуваарилсан гэдэг билээ. Гэтэл үнэндээ үнэн бодитой Монголын “Дөчин есөн ноёд”, “Өвөр дөчин есөн хошуу” гэж байхгүй юм. Дөчин есөн гэж Монголын бүрэн бүтнийг хэлж байгаа юм. ⁽²⁰⁾

Дөчин илүү нь ч бас ийм утгаар хэрэглэгдэж байлаа. Дөчин есөн буюу дөчин илүүг барагцаалсан тоо гэж үзэж үл болно. Тэгвэл Гомбожавын энэ үзэлтийг холбогдол бүхий Монгол, Хятад сурвалж бичгүүдийн тэмдэглэлтэй харьцуулж шинэ ухааралтыг олж болох юм. 14 дүгээр зууны сүүлч, Мин улсын эхний үед Хятад усэг бээр зохиогдсон “Юань улсын Түүх”-д Чингис хааныг “Дөчин улсыг сөнөөжээ” гэдэг. Перс үсэг дээр зохиогдсон “Төмөр Хааны Цааз”-д Төмөр Хааны захиргаан доор Түрэг-Монголын “дөчин аймаг” байсан гэдэг юм.⁽²¹⁾ Бас 16 дугаар зууны сүүлд Мин Улсын Ван эми хаанаас гуравдугаар Далай Лама Содномжамцад өгсөн урилгын бичигт “Монголын дөчин их аймаг”⁽²²⁾ гэж бичиж байлаа. 1735 онд Харчины Луумийн зохиосон “Монголын Боржигид овгийн түүх”-д Чингис хааныг “Суурин дор хорин дөрвөн жил суугаад дөчин улсыг”⁽²³⁾ сөнөөв” гэжээ.

Өнгөрсөнд цөөн бус хүмүүс эдгээр дөчин улс буюу дөчин аймгийг Чингис хаан, Төмөр-лан хааны эрхшээлдээ оруулсан улс, гүрний үнэн бодитой тоогоор ойлгож зарим хүмүүс тэдгээрийг нэг, нэгээр тодолхоор оролдоод мөхсөн билээ. Олны мэдээжээр Чингис хаан 12 дугаар зууны сүүл. 13 дугаар зууны эхээр хэдэн арван жилийн ширүүн дайн байлдааныг хийж их төлөв говийн ар, өврийн Монголын олон аймгуудыг нэгтгэж 1206 онд Монгол Улсаа байгуулжээ. 1206 оноос 1227 онд Чингис хаан нас барах хүртэл хорь гаруй жилийн хугацаанд Зүрчидийн Алтан улстай дайн байлдаан хийснээс гадна Хар, Хаант улс, Хар Кидан, Хорезм улс, Тангад улсыг сөнөөж, голдуу Тэнгэр уулын дээд, доод орон, Дундад Ази, Хивчагийн тал нутаг дахь Хүргүүдийн олон аймаг, ястанг эрхшээлдээ оруулжээ. Тухайн үед Чингис хаан болон түүний доорхи ноёд, түшмэд Түргүүдийн Эл аймаг,

ястаны хүмүүсийг өөрийн нэгэн угсаа төрлийн хүмүүс гэж үзэж байсан юм.⁽²⁴⁾ Түргүүдийн эл аймаг ястаны хүмүүс ч Монголын хүчирхэгжин мандахыг дагалдаж өөрсдийгөө Монгол гэж хэлдэг байлаа.⁽²⁵⁾ Төмөр лан хаан 14 дүгээр зууны сүүлийн үед юуны өмнө баруун Цагаадай Хаант Улсыг эрхшээлдээ оруулан дараа нь Хивчаг Хаант Улс болон Их Хаант Улсын Түрэг-Монголын олон аймгуудыг дахин нэгтгэсэн юм. Эдээрээс үзвэл, дөчин түмэн, дөчин улс, дөчин аймаг, дөчин есөн улс, дөчин илүү улс, дөчин түмэн ертөнц гэдэг нь бүр 13 дугаар зууны Чингис Хаснаас дараах Дөчин Түмэн Монгол Улс буюу Дөчин Түмэн Монголын адил бус хэллэг болох бөгөөд Түрэг-Монголын эл аймаг, ястаны түгээмэл нийтлэг нэрийдэл болно. Чингис Хаан дөчин улсыг сөнөөсөн гэдэгийг Түрэг-Монголын бүх аймаг, ястангуудыг нэгтгэсэн гэж ойлгох хэрэгтэй. Төмөр лан хааны захиргаан доорхи дөчин аймаг гэдгийг Түрэг-Монголын олон аймаг гэж ойлгох хэрэгтэй.

Жамбалдорж 1849 онд “Болор толь”-оо бичээд одоо болтол зуун тавиад жил боллоо. Энэ хооронд Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн талаар дорвитой судалгаа хийгдээгүй бөгөөд одоогийн монгол түүхчидийн үзэлт нь хоёр зуун далаад жилийн өмнөх Гомбожавын үзэлтэд хүрээгүй болой.

Ер нь Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн утга санаа, улиран хувьсгалт, хүрээ хэмжээг мэдье гэвэл эрхбиш түүний үүсэл, ирэлтийн цаг үеийг тодлох чухалтай. 17-19 дүгээр зууны үеийн эл зүйлийн Монгол, Хятад сурвалж бичгийн тэмдэглэлээс энэхүү нэрийдлийн үүссэн бодитой цаг үеийг мэдэж чадахгүй юм. 1620 онд Нурхачийн эсэргүүцлийн бичигт: Лигдэн хаан өөрийгөө дөчин түмэн Монголын Эзэн гэснийг “Эртний хуучин үг” гэжээ. Тус бичгийн бүх агуулгаас үзэхэд: Энэхүү “Эртний” гэсэн үгийг Мин улсын Зу Юаньзан Юань Улсын Их нийслэл Бээжин хотыг эзэлсэн 1368 оноос өмнөх цаг үеийг заасан гэж үзэж болох юм. Зохиогчийн нэргүй “Алтан товч”, “Асрагч нэртийн түүх”, 1774-1775 оны үед зохиогдсон Раашпунцагийн “Болор Эрх”-д Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн үүссэн цаг үеийн тухай дурдаагүй билээ.

Дээр өгүүлсэн Лувсанданзаны “Алтан товч”-д Чингис хаан нас барсны дараа Толуй болон түүний хүүхэд, ач нарыг “Их голомт дор төвлөн дөчин түмэн монголын эзэн боллуга” гэдэг, Луумийн “Боржигод овгийн түүх”-д Чингис хааныг “Суурин дор хорин дөрвөн жил суугаад дөчин улсыг сөнөөв” гэжээ. Энэ хоёр зүйлийн тэмдэглэлийг үндэслэн Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдэлт нь Чингис Хаан 1227 онд таалал болоход үүссэн гэж хэлж үл болох, харин тэр үед Жамбалдоржийн “Болор толь”-д: “Монгол урд дөчин түмэн байсан” гэдэг. Энэхүү “урд” нь чухам аль цаг үеийг зааж байгааг мэдэхийн аргагүй юм.

Ийм учраас Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн үүсэл, ирэлтийг мэдье гэвэл өөр арга замыг хайх хэрэгтэй.

17-19 дүгээр зууны үеийн Монгол сурвалж бичгүүдэд Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн үүсэл, ирэлтийн цаг үеийг тэмдэглэсэн нь тодорхойгүй боловч Дөрвөн Түмэн Ойрад буюу дөрвөн Ойрад хэмээх нэрийдлийг Олонхи нь бүр Элбэг нигүлсхүй Хааны үед

үүссэн гэж буй. Энэ нь элбэг Нигүлсхүй хаан болон Хун гэвээ Бэх хоёрын домогийг үндэслэн хэлсэн юм.

Учир нь Элбэг нигүлсхүй хаан 1399 онд Ойрадын Үгэй Хасхад алагдав. Арван жилийн дараа 1409 онд Мин Улсаас Ойрадад Ван өргөмжлөхдөө гурван ван өргөмжилснөөс биш, харин дөрвөн ван өргөмжлөөгүй юм.⁽²⁶⁾ Хэрэв дөрвөн Ойрад хэмээх нэрийдлийг Элбэг Нигүлсхүй хааны үед байсан гэвэл, тэр нь Дөрвөн Түмэн Ойрадыг хэлж байгаа биш. Харин 13 дугаар зууны үеийн дөрвөн мянган Ойрадын Хойчисыг хэлж байгаа. Тод Монгол сурвалж бичгийн тэмдэглэлийг үндэслэвэл: Түрүүн Дөрвөн Ойрад 1437 онд ор тогтож Дөрвөн Ойрад нь гурван үе шатыг өнгөрүүлсэн ажээ.⁽²⁷⁾ Тэгвэл 1437 онд үүссэн дөрвөн Түмэн Ойрад болон 1491 онд үүссэн зургаан Түмэн Монгол хэмээх нэрийдлийг 1368 онд Мин Улс Бээжинг эзлэх үеийн Монголын Дөчин Түмэнтэй хутгалдуулан хэлэх нь үнэн хэрэг дээрээ хожим үеийн шинэ нэрийдлээр эртний хуучин нэрийдлийг орлуулсан явдал болно. Даян хааны үеийн Зургаан Түмэн Монгол нь Монгол, Ойрад хоёрын гол цогц болсон учраас тэр нь зургаан Түмэн Монгол хэмээх шинэ нэрийдлийг хэрэглэхтэй зэрэг бас угийн Дөчин Түмэн Монгол хэмээх хуучин нэрийдлээ хэрэглэдэг байжээ. Ийнхүү Сагаан Сэцний “Эрдэний товч”-д Зургаан Түмэн Монгол, Дөрвөн Түмэн Ойрад гэж хэлэхийн хамт бас Монгол, Ойрад хоёрыг Дөчин, Дөрвөн хоёр гэж хэлдэг байжээ. Үүнийг хоорондоо зөрчилтэй гэж хэлж болохгүй.

16-19 дүгээр зууны үеийн Монгол сурвалж бичгүүдэд 1206- 1635 оны дөрвөн зуун гучаад жилийн Монгол Хаант Улсыг Дөчин Түмэн Монгол Улс гэж нэрийдхийн хамт түүнтэй харьцуулан нэрийдсэн улс, угсаатны нэр ч өдий төдий байдаг юм. Жишээлбэл: “Усны Гурван Түмэн Зөрчид”, “Арван гурван муж. Наян Түмэн Хятад”, “Арван Гурван Түмэн Төвд”, “Найман мянган Хойд”⁽²⁸⁾ гэх мэт. Эдгээр нэрийдлийн үүсэл, ирэлтийн цаг үеийг Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлээс илүү амархан мэдэж болох бөгөөд тэдгээр нь Монгол ардын аман зохиол “Жангар”-ын туульд, зарим нь монголоор дамжин Мин улсын үеийн зарим хятад сурвалж бичгүүдэд тусгагдан тэмдэглэгдсэн байдаг юм. Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн цаг үеийг тодлохоос өмнө эдгээр нэрийдлийн үүсэл, ирэлтийг товч өгүүлэх чухалтай байна.

Дээр өгүүлснээр 1619 оны Лигдэн хааны улсын бичигт Нурхачийг “Усны: Гурван Түмэн Манжийн эзэн хөндлөн гэгээн хаан” гэжээ. “Хөндлөн Хаан” гэдэг нь 1999 онд Монголын өвөр таван халхын Баягууд отогийн Дархан баатар ноёны хүү Энхтөр тайж хамгийн түрүүнд Зөрчидэд бууж өгөх үедээ Нурхачийг хүндэтгэн өргөмжилсөн цол болно.⁽²⁹⁾

1635 онд Эжэй Хонгор тэргүүтэй Монголын дөчин есөн ноёд Манжийн Сэцэн хаанд бууж өгсний дараа “Манж хаан тэрээр Чингисийн тамга авч эзэлсэн тул Монголын Хаан болбой” гэж хэлдэг байв. Үүний хамт шарын шашны Хутагт хувилгадаас Монгол Хаант Улсын тулгуур төрийг байгуулсан Суут Богд Чингис хаан болон түүний залгамжлагчдын элдэв зүйлийн бурхан сахиусны хувилгаан гэж хэлэх болжээ. Шашны ухуулгыг Манжийн хаан дуртай хүлээн авах ёстой.

1636 оны үеэр Манжийн Сэцэн хаан өөрийн үндэстний Зөрчид хэмээх нэрээ өөрчилж Манж гэх болсон юм. 1817 онд зохиогдсон “Алтан Эрх”-ийн тайлбараар: “Манж” нь бурханы нэр “Манзушири”-ээс авсан гэнэ. Энэ нь Чин Улсын манж хаадаас үе улиран Утайн таван уулын гол шүтээн Манзушири бурханыг хүндэтгэн тахидаг хэвшилтэй нийцэж байна.⁽³⁰⁾ 1619 оны Лигдэн хааны улсын бичгийн уг эхэд “усны гурван түмэн Зөрчид” гэж байсныг Чин Улсын “Тайз хааны магад хууль”-ийг зохиоход “усны гурван түмэн Манж” гэж өөрчилсөн байх. Тан улс (м.э.618-907 он)-ын үед Зөрчидийг хятад сурвалж бичгүүдэд “Мэхээ” гэдэг байжээ. “Мэхээ” нь усан гэдэг утгатай Зөрчид үг юм. 13 дугаар зууны үед Хятад, Франц, Персийн эл зүйлийн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсэн “усан монгол” буюу “Усан татар” нь эртний мэхээ, Зөрчдийн зарим хойчисыг хэлж байсан бололтой. Юань улсын эхний үед Сунгари мөрний дунд, доорд урсгал дагуу газарт Таван Түмэнийг байгуулж “усан татар”-ыг захируулсан байжээ. Юань улсын дараа “усан татар”-ын хоёр салбар нь урагш нүүдэлж гурван хэсэг болж салаад урьд хожид Ойрадын Эсэн хаан болон Монголын Түмэн засагт Хааны ноёрхолд орсон юм. Лигдэн хааны хэлдэг “усны гурван түмэн Зөрчид” нь яриангүй дээр өгүүлсэн Зөрчидийн түүхэн байдлыг үндэслэн хэлсэн⁽³¹⁾ бөгөөд Нурхачийн эсэргүүцэл нь ёсонд нийцэхгүй юм.

“Арван гурван муж хятад”, “Арван гурван түмэн Товд” зэрэг бол бүр Юань улсын үеийн засаг захиргааны хуваарилалыг үндэслэн нэрийдсэн нэрийдэл болно.⁽³²⁾ Монгол сурвалж бичгүүдэд арван гурван муж Хятад гэж хэлхээс гадна бас наян түмэн хятад буюу наян найман түмэн Хятад гэж хэлдэг юм. Зарим эрдэмтэд хятадын хүн амын тоо олон болохоор Монголчууд тэднийг наян түмэн Хятад гэж өөрийн дөчин түмэн монголоосоо нэг дахин илүү хэлдэг гэж үздэг. Гэтэл эртнээс одоо болтол хятадын хүн амын тоо монголоос зөвхөн нэг дахин илүү биш юм.

Хубилай хаан дотор газрыг дайлах үед гучин түмэн монгол цэрэг, наян түмэн Хятад цэргийг дайчилж Юань Улсаа байгуулж өмнөт Сун Улсыг сөнөөгөөд таван зуу гаруй жил тархай бутархай байсан хятад орныг нэгтгэсэн юм.⁽³³⁾ Монголчууд энэхүү агуу их түүхэн ач холбогдолтой ялалтыг дурсгаж наян түмэн Хятад гэж нэрийдсэн байхаа. Наян түмэн хятад гэдэг нь яриангүй Монголын дөчин есөнтэй харьцуулан зохицуулж нэрийдсэн нэрийдэл болно. Чингис хаан улс байгуулаад хүүхэд, дүү нартаа хувь олгохдоо Цагаадайд найман Мянганьг өгсөн юм. “Жангары”-ын туульд үргэлж гардаг наран суух зүгийн найман мянган ертөнц нь Цагаадай Хаант Улсыг хэлсэн юм. Дараа нь Цагаадай Хаант Улсын захиргаанд байсан болон Өгөөдэй. Цагаадай, Ариг бухын хойчисын зарим нь Ойрадтой холбоолж Найман. Мянган Хойд буюу Арууд гэж нэрийдэх болсон юм.⁽³⁴⁾ Энэ бүхнийг Монголчууд дур, тааваараа зохиосон зүйл гэж хэлж болохгүй. Дээр өгүүлсэн байдлаас үзвэл, Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн эх сурвалж нь 13 дугаар зууны Монголын хаант улсаас өмнөх эртний умар дахины угсаа үндэстний түүхэн дээрхи ямар нэгэн чухал түүхэн хэрэг явдлыг дурсаж үүсчээ. Тэгвэл энэхүү нэрийдэл нь

урт удаан жилийн түүхтэй бөгөөд олон удаагийн улиран хувьсгалыг өнгөрүүлсэн байх ёстой. Дөчин Түмэн Монгол Улс, Их Монгол Улс нь Чингис хаан 1206 онд улс байгуулаад дэмий удалгүй хэрэглэсэн нэг улсын адил бус нэрийдэл болно. Ийнхүү 17-19 дүгээр зууны үеийн зарим монгол сурвалж бичиг Дөчин Түмэн Монгол Улс, Их Монгол Улс хэлхээх хоёр нэрийдлийг холбож Дөчин Түмэн Монгол Улс гэж хэлдэг. Дөчин Түмэн Монгол Улс нэрийдлийг Монгол Хаант Улсын үед Монголчууд өөрсдөө хэрэгтэй байсан улс, гүрний жинхэнэ нэр мөн гэж хэлж болно. Юань Улс хэмээх нэрийдэл бол Дөчин Түмэн Монгол Улс нь Хятад орны эзлээд хятад үндэстний заншлаар, Хятадад зориулж 1271 он шинээр нэрийдсэн улс гүрний нэрийдэл болно. Монголчууд Юань улсыг ердөө бүр Дайюань-Дай Үнь-Их Үнь улс гэж хэлдэг юм. Юань улс нь эхлээд Дөчин Түмэн Монгол Улсын харъяат улсын чанартай хойно Дөчин Түмэн Монгол Улс нь Юань Улс, Цагаадай улс, хивчаг улс, Ил улс зэрэг дөрвөн улс болж задархыг дагалдаж Монголын төрөлх нутаг нь Юань улсын хүрээ хэмжээнд багтагдах болжээ. 1368 онд Тогоонтөмөр хаан Бээжингээс зайлж төрөлхи нутагтаа буцаж ирснээс 1407 онд Өлзийтөмөр Цагаадай улсын Самарканд хотоос буцан ирж Монголын хаан сууринг залгамжлах хүртлэх дөчөөд жилийн хугацаанд Монголчууд өөрийн улсаа мөн Дөчин Түмэн Монгол Улс буюу Их Монгол улс гэж нэрийдэхийн хамт бас Дайоань улс хэмээх нэрийг хэрэглэж хятад орныг дахин эзлэхээр оролдож байсан. Үүгээр барахгүй Тогоонтөмөр хаанаас хол хойш үеийн Ойрадын Эсэн хаан, Монголын Даян хаан ч Хятад газрын Мин улстай харьцахдаа өөрийгөө Дайноань хаан гэж хэлдэг байсан юм.⁽³⁵⁾ Гэтэл Дөчин Түмэн Монгол Улсын хамаг сүүлчийн Хаан Лигдэний үе болоод гадаадтай харьцахдаа Дөчин Түмэн Монгол Улсын тулгуур төрийг нээсэн Суут Богд Чингис Хаан болон өөрийн биеэ Дай юань хаан гэж хэлхээ болиод “Даймин хаан” гэж хэлдэг болжээ.⁽³⁶⁾ Үүнээс үзэхэд 1368 оноос хойш Дөчин Түмэн Монгол Улс нь Дай юань, Даймин хэмээх нэрийдлийг зарим үед гадаад харилцааны хэрэгцээнээс хэрэглэдэг байжээ. Дай юань болон Дайминг тухайн үеийн Монгол Улс гүрний жинхэнэ нэр гэж хэлж үл болно. Үүнээс гадна 1368 оноос 1407 Өлзийтөмөр хаан сууринг залгамжлах болтол 30 жилийн хооронд Дөчин Түмэн Монгол Улс нь зарим үед Мин улс болон Солонгост Умард, Хойд Юань улс гэж нэрлэгддэг байжээ. Эдгээр нэрийдлийг 17-19 дүгээр зууны үеийн цөөн тооны түүхчид ч хэрэглэдэг байжээ. Жишээлбэл: Раашпунцагийн “Болор эрх”-д Хойд Юань Улс, Дхармаа Гүүшийн “Алтан хүрдэн мянган хэгээст”-д Умар дахь Юань улс гэж байгаа.⁽³⁶⁾ 1407 онд Өлзийтөмөр Монголын хаан сууринг залгамжлахаас өмнө Гуйранч хэмээгч их эрхийг барьж Юань Улсын үеийн зэрэг цолыг хаяж улсын нэрээ Татар гэх болжээ.⁽³⁸⁾ Тэр үеэс эхэлж Мин улс ч дөчин Түмэн Монгол Улсыг Татар гэх болсон юм.⁽³⁹⁾ Энд Хойд Юань улс гэж түүхэт цаг үеийн өмнө, хойнохи дэс дараах үндэслэн нэрлэжээ. Умард Юань Улс гэдэг нь Хятад заншлаар зүг чиглэлээр нэрлэжээ. Татар гэдэг нь дундад Азийн Түргүүдийн заншлаар нэрлэжээ. Гэтэл тухайн үеийн монголчууд өөрийн улс гүрнээ Умард, Хойд Юань улс. Татар гэж ер хэлдэггүй байжээ. “Нэр нь эзнээ дагах, хэвшлийг баримтлах” гэдэг бол дэлхийн олон улсын дагаж мөрддөг зарчим журах билээ.

Эшлэл, зүүлт

1. И.Ринчин "Дундад улсын умар дахины угсаатнууд болон монголчуудын угсаа язгуур"- "Монголын түүхийн тухай өгүүллүүд" Хөх хот., 1981 т.1
2. "Дайчин улсын Тайцзу хааны магад хууль" 1-дүгээр дэвтэр т.147 Өвөрмонголын Соёлын Хэвлэлийн Хороо 1990
3. Мөн тэнд. 1 дүгээр дэвтэр, т.92
4. Мөн тэнд. 1 дүгээр дэвтэр т. 150
5. Мөн тэнд (хятадаар). 2 дугаар дэвтэр ,336. 1986
6. "Их Шар тууж" Бээжин., 1983 т. 100
7. Жамбалдорж "Болор толь", Үндэсний хэвлэлийн хороо 1984 т.444
8. Саган сэцэн "Эрдэнийн товч" 198: Өвөрмонголын Хэвлэлийн Хороо т.273, 329
9. "Алтан товч" УБ.,1990 т. 152
10. Жамбалдорж "Болор толь" т.439,499
11. Рашид Ад Дин: "Судрын чуулган" хятад орчуулга: боть 2-р дэвтэр т.11 1983
12. "Дайчин улсын Тайцзун хааны магад хууль" (монголоор). II дэвтэр т.109
13. Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ нар "Ойрадын түүхийн сурвалж" 1985 Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо ӨМСХХ; т. 131.
14. "Хаадын үндсэн хураангуй Алтан товч" 1980. Өвөрмонголын Ардын Хэвлэлийн Хорос ӨМАХХ) т.57,67
15. Лувсанданзан. "Алтан товч"136, 137, 141 2 алба "Асрагч Нэртийн түүх" .74, Дармаагүүш "Алтан хүрдэн, мянган хигээст"
16. Ишбалдан. "Эрдэнийн эрхи т.47. Копенгаген., 1963
17. "Ойрад судлал" 1991. № 1, 1992 № 3, 1993 № 1,2,3,4...
18. Лу "Алтан товч" т. 129
19. Гомбожав "Гангын урсгал" ӨМАХХ. 1981 т 49-51. "Дайчин улсын Тайцзун хааны магад хууль" 3-р дэвтэр т.772-773
20. "Дайчин улсын Тайцзун хааны магад хууль" 3-р дэвтэр т.772-773
21. "Юан улсын түүх" I боть № т.229 Синьцзяны ардын хэвлэлийн хороо, 1983
22. "Болор толь" т.467
23. Лууми. "Монголын Боржигод овгийн түүх" т.55 ӨМАХХ : 989
24. "Судрын чуулган" 1 боть, 2-р дэвтэр .. 314
25. Мөн тэнд 1 боть 3-р дэвтэр т.127-128
26. "Мин улсын багцхүн хааны магад хууль" 63-р боть
27. Алтан-Оргил: "Ойрадын түүхэн сурвалж бичиг" г. 6-144
28. "Эрдэнэтунамал нэрт судар" 75
29. "Дайчин улсын тайцзу хааны магад хууль" монголоор: I дэвтэр 1990 т. 67-68
30. "Болор толь" т. 486
31. Хуучин Тан улсын бичиг" 1975 т.5358 Жүнхуагийн номын товчоо
32. "Юан улсын түүх" 58-63 боть, т.1345-1580
33. "Болор толь" т. 415 442
34. "Монголын Нууц Товчоо" Гутгаар дэвтэр т. 159 ӨМАХХ 1981
35. "Мин улсын Инцзун хааны магад хууль" боть 234 "Эрдэнэ тунамал нэрт судар" т.20